



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/013/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Н.Ариунтуяа

Утас: 94004399

Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.03.25 № 2/25
танай _____-ны № _____-т

ДӨРГӨН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Л.ЦЭДЭН- ИШ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.6, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолын 3.4.10 дахь заалтуудыг тус тус мөрдөөгүй иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, эцсийн санхүүжилтийг хүлээн авсан акт, анхан шатны баримт дутуу 59,984.0 мянган төгрөгийг олгосон,
- Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эвлэрлийн гэрээ байгуулсан зээлдэгч нарын зээлийг хугацаанд нь төлүүлээгүй,
- Малын тоо толгойн албан татварын орлого 11,562.1 мянган төгрөгөөр тасарсан нь төлөвлөлтийг үндэслэлтэй төлөвлөх зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дөргөн сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 777,723.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 136,344.1 мянган төгрөгөөр буюу 121.3 хувиар давуулан биелүүлжээ.

Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны малын тоо толгойн албан татвар, газрын төлбөр, хүү торгуулийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	790,439.00	1,073,552.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	449,967.90	699,989.20
33	АВЛАГА	197,141.60	152,883.20
34	УРЬДЧИЛГАА	104,189.30	157,709.00
35	БАРАА МАТЕРИАЛ	39,140.20	62,970.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,652,688.40	2,734,649.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,652,688.40	2,734,649.10
39200	Биет хөрөнгө	2,618,492.20	2,700,558.30
39300	Биет бус хөрөнгө	34,196.20	34,090.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,443,127.40	3,808,201.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	17,430.90	23,858.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,430.90	23,858.80
41300	Өглөг	17,430.90	23,858.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,425,696.50	3,784,342.50
51	Засгийн газрын хувь оролцоо	3,425,696.50	3,784,342.50
51100	Засгийн газрын оруулсан капитал	795,806.10	795,806.10
51200	Хуримтлагдсан үр дүн	2,447,721.30	2,807,567.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	182,169.00	180,969.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,443,127.40	3,808,201.30

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,260,350.20	2,806,869.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	450,969.10	758,455.10
110	Орлогын албан татвар	383,016.70	677,500.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	400,986.30	698,257.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-17,969.60	-20,756.70
113	Хөрөнгийн албан татвар	46,822.90	57,652.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	21,129.50	23,302.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	543,984.30	367,044.80
120	Нийтлэг татварын бус орлого	543,984.30	367,044.80
124	Зээлийн орлого	0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,265,396.80	1,681,369.30
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,833,976.90	2,414,478.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,833,976.90	2,414,478.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,754,686.80	2,381,645.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409,377.20	731,413.50

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,474.60	91,665.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,578.70	589,585.50
2104	Хангамж, бараа материалын зардал	521,875.20	577,387.60
2105	Нормативт зардал	281	1,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,506.60	11,147.50
2107	Томилолт, зочны зардал	4,772.00	8,668.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	414,027.80	32,814.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	312,793.60	337,763.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,079,290.20	32,833.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	426,373.30	392,390.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	24,385.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	426,373.30	368,005.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,845,323.90	2,563,465.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	450,969.10	758,455.10
110	Орлогын албан татвар	383,016.70	677,500.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	400,986.30	698,257.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-17,969.60	-20,756.70
113	Хөрөнгийн албан татвар	46,822.90	57,652.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	21,129.50	23,302.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,352.30	4,201.50
1181	Газрын төлбөр	18,667.80	16,902.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	109.4	2,199.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,961.20	123,640.70
120	Нийтлэг татварын бус орлого	65,961.20	123,640.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,328,393.60	1,681,369.30
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,167,714.50	1,675,851.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,167,714.50	1,675,851.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,086,235.50	1,642,478.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,575.80	732,261.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,954.80	91,560.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,755.20	589,585.50
2104	Хангамж, бараа материалын зардал	35,291.70	38,786.80
2105	Нормативт зардал	419	1,697.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,826.60	28,393.60
2107	Томилолт, зочны зардал	4,772.00	10,115.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	416,431.40	38,225.60

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,209.00	111,852.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,081,479.00	33,373.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	677,609.40	887,613.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	441,162.50	634,492.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	441,162.50	634,492.10
2200	Дотоод эх үүсвэрээр	441,162.50	634,492.10
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-441,162.50	-634,492.10
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-100	-3,100.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100	3,100.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	236,346.90	250,021.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	213,621.00	449,967.90
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	449,967.90	699,989.20

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,999,323.20	2,999,323.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,999,323.20	2,999,323.20
9	Тайлант үеийн үр дүн	426,373.30	426,373.30
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,425,696.50	3,425,696.50
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,425,696.50	3,425,696.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-8,159.90	-8,159.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,417,536.60	3,417,536.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,199.70	-1,199.70
19	Тайлант үеийн үр дүн	368,005.60	368,005.60
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,784,342.50	3,784,342.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,691,825.80	2,260,036.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,736,272.90	1,622,444.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,681,784.50	1,597,645.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	738,856.10	732,261.50
210101	Үндсэн цалин	383,265.90	407,840.97
210102	Нэмэгдэл	292,822.10	250,489.40

210104	Урамшуулал	39,008.10	49,057.72
210105	Гэрээт ажлын хөлс	23,760.00	24,873.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,384.30	91,560.60
210201	Тэтгэврийн даатгал	62,828.90	62,329.03
210202	Тэтгэмжийн даатгал	7,388.90	7,329.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,911.10	5,851.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,477.70	1,477.70
210205	Эрүүл мэндийн даатгал	14,777.70	14,573.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	630,358.10	589,585.52
210301	Гэрэл, цахилгаан	31,560.00	25,544.05
210302	Түлш, халаалт	590,655.80	561,642.57
210303	Цэвэр, бохир ус	8,142.30	2,398.90
2104	Хангамж, бараа материалын зардал	39,148.30	36,394.40
210401	Бичиг хэрэг	5,356.80	5,352.55
210402	Тээвэр, шатахуун	26,917.80	25,473.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,873.70	3,577.15
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000.00	1,991.00
2105	Нормативт зардал	1,753.70	1,697.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,753.70	1,697.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,766.60	10,704.76
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317.00	198.30
210604	Урсгал засвар	10,449.60	10,506.46
2107	Томилолт, зочны зардал	8,861.60	10,115.50
210702	Дотоод албан томилолт	8,861.60	8,668.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	1,447.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,654.80	36,562.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,992.80	33,495.84
210803	Даатгалын үйлчилгээ	346.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,785.00	1,610.35
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	34.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,189.50	1,149.00
210807	Газрын төлбөр	307.50	307.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,001.00	88,763.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119,432.20	86,417.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,568.80	2,345.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,488.40	24,798.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,488.40	24,798.29
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,544.90	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,102.00	23,047.49
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,841.50	1,750.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	852,452.90	634,492.12
220001	Барилга байгууламж	349,445.00	228,981.25
221001	Их засвар	138,731.40	120,735.85
222001	Тоног төхөөрөмж	66,600.00	45,943.75
223001	Бусад хөрөнгө	297,676.50	238,831.27
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	103,100.00	3,100.00

230001	Эргэж төлөгдөх зээл	103,100.00	3,100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,691,825.80	2,411,177.74
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,288,274.80	2,323,889.72
320001	Орон нутгийн төсвөөс	1,693,567.90	1,729,182.82
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	594,706.90	594,706.90
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	403,551.00	87,288.02
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.00	605.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,100.00	86,683.02
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	299,846.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	218,005.04
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	369,146.59
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	60	60
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	3	3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29	29
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8
650010	Гэрээт ажилтан	3	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,701.60	35,718.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,701.60	35,718.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,701.70	27,144.14
2104	Хангамж, бараа материалын зардал	6,813.40	2,392.40
210402	Тээвэр, шатахуун	6,813.40	2,392.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	715.40	1,662.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	715.40	1,662.91
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,172.90	23,088.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,172.90	23,088.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,574.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	8,574.73

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		8,574.73
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	88,701.70	35,718.86
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,701.70	35,718.86
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,180.00	31,476.92
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,789.50	2,203.11
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,732.20	2,038.83

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар ОНХС, ХХС, ТТЗ-ийн нийт 75,099.3 мянган төгрөгийн 6 алдаа¹ зөрчил илэрсэн. Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчилд² 3,553.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 71,546.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын 3,553.2 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг суутган аваагүй, авлагаар бүртгээгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

3.1 Зөвлөмж

3.2.1. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Эвлэрлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг албадан гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулан ШШГА-тай гэрээ байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", "Хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай" шүүгчийн захирамжуудын заалттай тус тус нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Эвлэрлийн гэрээний хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдлийг хууль хяналтын байгууллагад хандаж албадан гүйцэтгүүлэх арга хэмжээ авах

3.2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ажлын даалгавар, төсөв, тендерийн баримт бичиг, гүйцэтгэсэн ажлын тайлан хавсаргаагүй, анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй зөрчил нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын заалтуудыг мөрдөж ажиллаагүй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Захиалагчийн хяналт хэрэгжүүлэн, ажлын хэсэг томилон ажлыг актаар хүлээн авч акт үйлдэн гэрээг дүгнэж, анхан шатны баримтууд бүрдэл болсны дараа үлдэгдэл санхүүжилтийг олгох

3.2.3. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд малжуулах хөтөлбөрийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.5-д "Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах

3.2.4 Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд журамд заасан дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчил нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.2.2-т "Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих", гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн хөгжлийн сангийн журамд заасны дагуу дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллах

3.2.5 Орон нутгийн татварын орлоготой холбоотой асуудлаар

Илрүүлэлт: Малд ногдуулах албан татварын орлого 11,562.1 мянган төгрөгөөр тасарсан нь төлөвлөөг үндэслэлтэй төлөвлөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" Дөргөн сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 19/02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Малын тоо толгойн албан татварыг тооцоо судалгаатай үндэслэлтэй төлөвлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 07 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Дөргөн сумын ТТЗ	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд журамд заасан дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй	1	-		-				1	-		
	Малжуулах хөтөлбөрийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн	1	-						1	-		
	Батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулан шалгахад малын тоо толгойн албан татварын орлого 11,562.1 мянган төгрөгөөр тасарсан.	1	11,562.1						1	11,562.10		
	Эвлэрлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг албадан гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулан хууль хяналтын байгууллагатай гэрээ байгуулаагүй	1	-						1	-		
	Төсвийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, төсөв, тендерийн баримт бичиг, гүйцэтгэсэн ажлын тайлан	1	59,984.0						1	59,984.00		

хавсаргаагүй, анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй санхүүжилт олгосон										
Захиалагчийн хяналтын зардлыг суутган аваагүй	1	3,553.2	1	3,553.2						
Нийт дүн	6	75,099.30	1	3,553.2	0	-	5	71,546.1	0	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		